

БАЙГАЛИЙН УХААНЫ УНШЛАГЫН ТАНХИМЫН ДРОЖИЙГ ХУЛДААСААР СОЛИХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ажлын нэр: Байгалийн ухааны уншлагийн танхимын дрожийг PVC хулдаасаар солих

Байршил: МУИС-ийн номын сангийн 3 дүгээр давхарт

Нийт талбайн хэмжээ: 546,47м² талбаатай. Үүнээс зөвхөн дрожтой хэсгийг буюу 350м² гаруй талбайн дрожыг хуулаж, хулдаасална.

Шалны ажилд тавигдах шаардлагууд:

1. Ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөж буй хууль, тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
2. Шалны ажлыг захиалагчаас өгсөн ажлын тоо хэмжээнд хийнэ.
3. Шалны хуучин дрожийг хуулж, шалны гадаргууд зориулалтын материал (орос бандер)-аар тэгшилгээ хийж, 100 хувь хатаасны дараа сайн чанарын хөрсжүүлэгчээр гадаргууг бүрэн бүрж, далд ажлын акт үйлдэн захиалагчид үзүүлж норм дүрмийн шаардлага хангасан гэж үзвэл дараагийн ажлыг эхлүүлнэ.
4. Засварын ажилд хэрэглэх хулдаасны чанар нь:
 - Солонгос улсад үйлдвэрлэсэн 1,8мм-ээс дээш зузаантай, PVC материалтай, өнгөний пилонкон хамгаалттай хулдаас эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай.
 - Хальтиргаа, элэгдлийн хамгаалалттай: Хатуулаг бие, тунгалаг давхарга нь хэт ягаан туяа болон хальтиргаа, элэгдлээс хамгаалах давхаргатай
 - 100% усны хамгаалалттай: Усны хамгаалалт өндөр, чийг даахгүй материалын чанарт өөрчлөлт орохгүй
 - Байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй: Формальдегид буюу үнэртэй, цавуулаг, шатамхай бодис агуулаагүй, гал дэмждэггүй, байгаль орчинд ээлтэй, дотор агаарын чанарт нөлөөлөх дэгдэмхий эдийн ялгаруулалтгүй, хүний биед сөрөг нөлөө хамгийн багатайгаар нотлогдсон байх,
 - Доргионы болон дуу чимээний хамгаалалттай

5. Ерөнхий тавигдах шаардлага:

- Засварын ажилд хэрэглэгдэх материал, хийц эдлэхүүнийг Монгол улсын үндэсний стандарт болон олон улсын стандартын шаардлага хангасан буюу түүнтэй дүйцэхүйц үзүүлэлттэй чанарын баталгаа, сертификаттай байхаар сонголтыг хийнэ.
- Засварын ажилд хуучин хэрэглэгдэж ашиглагдсан, чанар, эдэлгээний хугацаа нь богиноссон материал, түүхий эд, хийц эдлэхүүн хэрэглэхийг хориглоно.
- Материал, түүхий эд, хийц эдлэхүүн нь орчин үеийн хэлбэр хийц загвар, чанартай, шинжлэх ухааны дэвшлийг ашигласан, сүүлийн үеийн чиг хандлагад нийцсэн, олон улсын стандарт, чанарын шаардлага хангасан, сертификаттай байж болно.
- Засварын ажлын явцад далд ажлын актыг ажил тус бүрд нь бичиж, тухайн үед нь фото зургаар баримтжуулан, захиалагчаар гарын үсэг зуруулан баталгаажуулсан байна.
- Материалын сонголт, өнгийг тухай бүр захиалагчтай зөвлөж, техникийн тодорхойлолтод заагдсан болон түүнтэй дүйцэхүйц чанартай материалыг сонгож хэрэглэнэ.
- Галын аюулгүй байдлыг онцгой анхаарч норм дүрмийн шаардлагын дагуу ажлаа гүйцэтгэнэ.
- Засварын ажлын явцад эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын шаардлагыг хангаж ажиллах ба ажиллагчдын ажиллах аюулгүй ажиллагааны талаар тогтмол

зааварчилгаа өгч, хөдөлмөр хамгааллын хувцас бүрэн хэрэглэсний дараа ажлын байранд гаргаж байна. Мөн ажлын байрыг эмх цэгцтэй байлгана.

- Засвараас гарах хуучин материалуудыг гэмтээлгүйгээр буулгаж захиалагч болон байрын зохион байгуулагчид бүрэн бүтнээр нь баримтаар хүлээлгэн өгнө.
- Засвараас гарсан дрож болон бусад хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, хогийн цэгт хаясан байх

Техникийн тодорхойлолт хянасан:

МУИС-ийн Номын сангийн захирал



Г.Цэрэн

Техникийн тодорхойлолт бичсэн:

Хангамж, үйлчилгээний газрын барилгын инженер

Д.Оюунтогтох

2026.03.17